

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	11
4	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/313
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Д.Нарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн мөнгөн хөрөнгө, өр авлага, үндсэн хөрөнгийн бүртгэлийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 28-наас 2019 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нийслэл аудит ХХК-ын чанарын хяналтын менежер Б.Хөхөө, аудитор Д.Ариунбулган, аудиторын туслах Д.Ариунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн №54 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь Оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар Монгол хүний дундаж наслалтыг уртасгана гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дүрэм зохион байгуулалтын бүтцийг батлах тухай А/33 тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн нийгмийн эрүүл мэндийн чиглэлийг үндэсний түвшинд хэрэгжүүлэн мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох
- Хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм, зан үйл, орчны хүчин зүйлсийг тогтоох, үнэлэх, чиглэлээр судалгаа хийх, тандах, хянах судалгааны үр дүнг

нийтэд болон холбогдох байгууллагуудад мэдээлэх, ухуулан сурталчлах, практикт нэвтрүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх

- Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, зонхилон тохиолдох өвчний эрт илрүүлгийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, мэдээлэх, хянах, үүнд салбарын байгууллагуудын оролцоог хангах, лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэх
- Бусад салбарын бодлого, үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах ажил зохион байгуулах, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, лавлагаа зөвлөмжөөр хангах
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв дэх нийгмийн эрүүл мэндийн нэгж, орон нутгийн Нийгмийн эрүүл мэндийн нэгж, халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр ажилладаг мэргэжлийн төвүүдэд мэргэжил арга зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх
- Биотехнологийн вакцин, биобэлдмэлийг турших, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх зэрэг болно.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд дээрх бодлого журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт,

холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд тус төв нь Эрүүл мэндийн яамнаас удирдлага болгон гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэн үзсэний дүнд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Винница" програмыг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянан үзэхэд дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасан 6 чиглэлийн хяналтын ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардалийн 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн нийт орлогод төсөл хөтөлбөрийн санхүүжилт дийлэнх хувь эзэлдэг тул нийт зардлын хэмжээ нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх үзүүлэлт гэж үзэн материаллаг байдлын суурь болгон сонголоо.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны *нийт зардал* 1.783.713,6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 35,674.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт тус байгууллагын хувьд харьцангуй бага эрсдэлтэй гэж үзэн материаллаг байдлын түвшинг хоёр хувиар сонгосон болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэн 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож үүнээс 2 асуудалд аудитын явцад залруулга хийж, 3 асуудалд зөвлөмж өгөн, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	10,919.3	
	Дүн	3	10,919.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж Нийгмийн эрүүл мэндийн төвийн удирдлагад танилцуулж Аудитын үр дүнг танилцуулсан талаарх мэдээлэл Г301 маягтаар баталгаажууллаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд тус төв нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэнд 853,957.7 мянган төгрөгийг хүлээн авч урсгал зардалд зарцуулсан байна. Гэвч 2018 оны санхүүгийн тайлангаар урьдчилж төлсөн тооцоо дансанд 344,617.9 мянган төгрөгийн төслийн гэрээт ажлын үлдэгдэлтэй байна. Эдгээр зардлыг хүлээн зөвшөөрсөн орлоготой зөв уялдуулан бүртгэсэн эсэхийг авч үзэх. Мөн тус төвийн 15 ажилтны цалин, шимтгэлийг Эрүүл мэндийн яамнаас олгож байгааг холбогдох газарт хандан санхүүжилтийн асуудал шийдвэрлүүлэх зэрэг асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой нэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,160,954.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,159,754.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь нийт дүнгээр төсвийн зардлыг 0,1 хувиар буюу 1,200.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Мөн цэвэр бохир усны зардлыг Түлш, халаалтын зардал руу тээвэр шатахууны зардлыг бичиг хэрэг, шуудан, холбооны зардал руу бүлэг дотор гүйлгэн зарцуулсан байна. Энэ зарцуулалт нь төсвийн төсөл боловсруулахдаа дээд шатны төсөв захирагч нь тухайн байгууллагын саналыг харгалзан үзээгүйтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант жилд шилэн дансны цахим хуудсанд нийт 148 төрлийн мэдээллийг байршуулахаас 131 мэдээ буюу 88,5 хувийг цаг хугацаанд нь оруулж үлдэх 17 мэдээ буюу 11,5 хувийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн. 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх аудитаар өгөгдсөн 4 зөвлөмжөөс 3 зөвлөмжийг бүрэн биелүүлж 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар тус төвийг бүтэц зохион байгуулалт үйл ажиллагааны чиглэлээрээ Эрүүл мэндийн яаманд байдаг боловч БСШУСЯ-ны харьяа Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжилт авч байгаа асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн яам болон БСШУСЯ-нд 2018 оны 12 дугаар сард 577 тоот албан бичгээр хүсэлт явуулсан боловч БСШУСЯ 2018 оны 12 дугаар сард 6/14785 тоот албан бичгээр шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөг/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад

илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Тавилга, аж ахуйн эд хогшлын элэгдлийг 333.4 мянган, Машин тоног төхөөрөмжийн элэгдлийг 4,580.1 мянган нийт 4,913.5 мянган төгрөгөөр тус тус илүү байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв” байх, УСНББОУС 17.66-д “Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны турш системтэйгээр хуваарилна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг холбогдох стандарт, хуулийн дагуу үнэн зөв тооцож байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Мөнгөн хөрөнгийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Тус төвийн кассын дансанд өмнөх оны үлдэгдэл болох 111.6 мянган төгрөг жилийн эцсийн байдлаар зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Мөн кассын няравын орон тооны ажилтангүй уг мөнгийг тооцооны нягтлан бодогч хариуцаж байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орос орлогыг (түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй) ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэнтэй нийцэхгүй байна.

Энэ нь Үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын Мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Өмч хөрөнгө шамшигдах, үрэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Жижиг мөнгөн сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг тухай бүр хийж үлдэгдлийг харилцах дансанд тушааж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Авлага, өр төлбөрийн талаар

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд цалин хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос 86,918.8 мянган төгрөгийн татвар суутгасан ба төсөвт 81,024.6 мянган төгрөгийн төлөлт хийж 5,894.2 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байгаа боловч санхүүгийн тайланд тусгаагүй, мөн 2018 оны 12-р сарын НДШ-ийн тайлангаар 263.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, тайлант хугацааны эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх, санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Тайлант онд төвийн ажиллагсдад олгосон цалин болон гэрээгээр ажил гүйцэтгэсэн хувь хүмүүст олгосон орлогыг тайланд үнэн зөв тусгаж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг холбогдох байгууллагаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгаж тайлагнаж байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 1-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	296,946,852.37	624,835,530.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	111,600.00	111,600.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	111,600.00	111,600.00
31110	Төгрөг	111,600.00	111,600.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
33	АВЛАГА	83,769,735.08	129,785,257.06
335	Бусад авлага	80,853,735.08	129,785,257.06
34	УРЬДЧИЛГАА	122,800,067.00	344,617,892.81
34600	Урьдчилж гарсан зардал	122,800,067.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	344,617,892.81
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	00.00	243,736,652.00
34713	Цалингийн урьдчилгаа	00.00	39,381,500.81
34714	Томилолтын урьдчилгаа	00.00	61,499,740.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,265,450.29	150,320,780.29
351	Түүхий эд материал	49,392,067.68	109,465,757.68
35110	Тусгай зориулалттай материал	49,392,067.68	109,465,757.68
354	Хангамжийн материал	40,873,382.61	40,855,022.61
35410	Бичиг хэргийн материал	7,053,441.91	7,035,081.91
35420	Аж ахуйн материал	7,059,778.90	7,059,778.90
35430	Сэлбэг хэрэгсэл	141,000.00	141,000.00
35470	Бусад хангамжийн материал	26,619,161.80	26,619,161.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	731,017,984.24	1,234,763,413.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	731,017,984.24	1,234,763,413.95
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	731,017,984.24	920,926,092.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	636,332,371.00	410,605,737.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-470,193,116.18	-2,700,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,387,927,708.19	1,410,441,708.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-859,524,868.44	-948,737,255.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,700,833.08	70,700,833.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,392,834.14	-64,956,897.32
39209	Зам, гүүрийн байгууламж	1,036,484,100.00	18,925,475.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,026,515,876.48	00.00
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	21,378,820.00	10,446,825.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-21,378,820.00	00.00
39217	Ном	16,199,667.21	16,199,667.21
393	Биет бус хөрөнгө	00.00	313,837,321.60
39301	Програм хангамж	2,473,000.00	2,473,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,473,000.00	-2,473,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	313,837,321.60
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,027,964,836.61	1,859,598,944.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,647,265.00	543,056.08
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,647,265.00	543,056.08
413	Өглөг	38,647,265.00	543,056.08
4136	Бусад өглөг	38,647,265.00	543,056.08
41361	Байгууллагад төлөх өглөг	38,647,265.00	543,056.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	989,317,571.61	1,859,055,888.03
51	Засгийн газрын хувь оролцоо	989,317,571.61	1,859,055,888.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,401,688,951.07	2,715,526,272.67

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	2,401,688,951.07	2,715,526,272.67
512	Хуримтлагдсан үр дүн	-1,571,602,512.06	-1,288,719,163.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,571,602,512.06	-1,571,602,512.06
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	282,883,348.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	159,231,132.60	432,248,778.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,027,964,836.61</u>	<u>1,859,598,944.11</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,101,964,183.68	2,066,684,138.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,828,300.00	30,457,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,828,300.00	30,457,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,828,300.00	30,457,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,828,300.00	29,221,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,235,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,092,135,883.68	2,036,226,638.29
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	464,641,700.00	1,130,954,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	464,641,700.00	1,130,954,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	627,494,183.68	905,272,238.29
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	625,087,575.68	648,827,051.29
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,406,608.00	254,180,535.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,264,652.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,110,410,661.76	1,783,713,598.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,110,410,661.76	1,783,713,598.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,110,410,661.76	1,781,414,420.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448,242,114.00	912,135,185.91
210101	Үндсэн цалин	448,242,114.00	597,755,510.91
210102	Нэмэгдэл	00.00	314,379,675.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,866,925.78	99,688,926.65
210201	Тэтгэврийн даатгал	27,002,364.48	69,580,435.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,086,916.40	7,750,897.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,856,548.75	6,200,716.62
210204	Ажилгүйдлийн даатгал	720,099.65	1,468,807.31
210205	Эрүүл мэндийн даатгал	7,200,996.50	14,688,070.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,589,188.00	63,079,499.59
210301	Гэрэл, цахилгаан	13,220,732.00	29,618,041.00
210302	Түлш, халаалт	17,206,456.00	24,465,965.00
210303	Цэвэр, бохир ус	5,162,000.00	8,995,493.59
2104	Хангамж, бараа материалын зардал	74,283,608.50	42,669,492.88
210401	Бичиг хэрэг	5,163,600.00	14,052,526.00
210402	Тээвэр, шатахуун	67,101,802.00	24,034,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,797,206.50	3,921,666.88
210404	Ном, хэвлэл	121,000.00	260,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	300,000.00
2105	Нормативт зардал	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	9,500,000.00
210604	Урсгал засвар	00.00	9,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	124,735,395.00	20,990,100.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	124,735,395.00	20,990,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,733,300.00	154,360,532.00

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,663,200.00	91,829,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	59,400,000.00
210807	Газрын төлбөр	00.00	969,232.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,960,130.48	478,990,683.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	289,601,651.00	373,454,336.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,358,479.48	105,536,347.23
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	2,299,178.55
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,299,178.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,299,178.55
213304	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,446,478.08	282,970,539.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	87,191.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	87,191.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-87,191.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,446,478.08	282,883,348.48

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,277,876,333.91</u>	<u>2,147,537,873.37</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,023,716.00	30,457,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,023,716.00	30,457,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,023,716.00	30,457,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,828,300.00	29,221,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,195,416.00	1,235,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,263,852,617.91	2,117,080,373.37
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	464,641,700.00	1,130,954,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	464,641,700.00	1,130,954,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	791,183,833.91	986,125,973.37
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	788,777,225.91	729,680,786.37
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,406,608.00	254,180,535.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,264,652.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,027,084.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,027,084.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,090,685,126.21</u>	<u>2,125,023,873.37</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,685,126.21	2,125,023,873.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,090,685,126.21	1,992,939,437.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,680,258.00	936,284,796.08
210101	Үндсэн цалин	406,531,058.00	810,501,694.08
210102	Нэмэгдэл	26,769,000.00	63,556,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,380,200.00	34,760,391.00
210104	Урамшуулал	00.00	5,989,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,866,309.71	96,865,171.40
210201	Тэтгэврийн даатгал	42,866,309.71	66,426,371.40
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	7,609,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,087,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,521,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	15,219,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,589,188.00	63,079,499.59
210301	Гэрэл, цахилгаан	13,220,732.00	29,618,041.00
210302	Түлш, халаалт	17,206,456.00	24,465,965.00
210303	Цэвэр, бохир ус	5,162,000.00	8,995,493.59
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,283,608.50	42,717,132.88
210401	Бичиг хэрэг	5,163,600.00	14,100,166.00
210402	Тээвэр, шатахуун	67,101,802.00	24,034,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,797,206.50	3,921,666.88
210404	Ном, хэвлэл	121,000.00	260,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	124,735,395.00	18,074,100.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	124,735,395.00	18,074,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,733,300.00	305,705,557.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,663,200.00	302,574,825.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	90,000.00
210807	Газрын төлбөр	00.00	969,232.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	293,797,067.00	551,690,091.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,195,416.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	289,601,651.00	551,690,091.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	132,084,435.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	132,084,435.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	132,084,435.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>187,191,207.70</u>	<u>22,514,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	22,514,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	22,514,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	22,514,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	22,514,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-22,514,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	187,191,207.70	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	111,600.00	111,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	187,302,807.70	111,600.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2.401.688.951.07	161,513,593.21	-1,937,034,724.59	00.00	626,167,819.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-2,282,460.61	00.00	-2,282,460.61
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	2,282,460.61	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	363,149,751.92	00.00	363,149,751.92
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,401,688,951.07	159,231,132.60	-1,571,602,512.06	00.00	989,317,571.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,401,688,951.07	159,231,132.60	-1,571,602,512.06	00.00	989,317,571.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	273,017,646.34	00.00	00.00	273,017,646.34
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	313,837,321.60	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	0.00	00.00	282,883,348.48	00.00	596,720,670.08
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,715,526,272.67	432,248,778.94	-1,288,719,163.58	00.00	1,859,055,888.03

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,160,954,400.00	1,159,754,096.45	1,200,303.55	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,160,954,400.00	1,159,754,096.45	1,200,303.55	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,160,954,400.00	1,159,754,096.45	1,200,303.55	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	782,323,300.00	782,295,542.17	27,757.83	100.0
210101	Үндсэн цалин	678,017,100.00	677,989,351.17	27,748.83	100.0
210102	Нэмэгдэл	63,556,000.00	63,556,000.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,760,400.00	34,760,391.00	9.00	100.0
210104	Урамшуулал	5,989,800.00	5,989,800.00	00.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	00.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,035,100.00	92,035,100.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	61,596,300.00	61,596,300.00	00.00	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	7,609,700.00	7,609,700.00	00.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,087,800.00	6,087,800.00	00.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,521,900.00	1,521,900.00	00.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	15,219,400.00	15,219,400.00	00.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,113,100.00	63,079,499.59	33,600.41	99.9
210301	Гэрэл, цахилгаан	29,487,100.00	29,618,041.00	-130,941.00	100.4
210302	Түлш, халаалт	26,426,000.00	24,465,965.00	1,960,035.00	92.6
210303	Цэвэр, бохир ус	7,200,000.00	8,995,493.59	-1,795,493.59	124.9
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,392,400.00	4,392,396.88	3.12	100.0
210401	Бичиг хэрэг	300,000.00	293,000.00	7,000.00	97.7
210402	Тээвэр, шатахуун	540,000.00	640,000.00	-100,000.00	118.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,152,400.00	3,098,496.88	53,903.12	98.3
210404	Ном, хэвлэл	200,000.00	260,900.00	-60,900.00	130.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	00.00	00.00	00.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	00.00	
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	116,000.00	384,000.00	23.2
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	00.00	
210702	Дотоод албан томилолт	500,000.00	116,000.00	384,000.00	23.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	00.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,590,500.00	217,835,557.81	754,942.19	99.7

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	215,429,000.00	214,704,825.81	724,174.19	99.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	00.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	71,500.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	90,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	00.00	
210807	Газрын төлбөр	1,000,000.00	969,232.00	30,768.00	96.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,160,954,400.00	1,159,754,096.45	1,200,303.55	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,130,954,400.00	1,129,296,596.45	1,657,803.55	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,130,954,400.00	1,129,296,596.45	1,657,803.55	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	30,000,000.00	30,457,500.00	-457,500.00	101.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	29,221,980.00	-9,221,980.00	146.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	1,235,520.00	8,764,480.00	12.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	111,600.00	-111,600.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	111,600.00	-111,600.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110.00	110.00	00.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	110.00	110.00	00.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	02.00	02.00	00.00	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	83.00	83.00	00.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	25.00	25.00	00.00	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	853,957,741.31	- 853,957,741.31	-
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	853,957,741.31	-853,957,741.31	-
4	Бараа, үйлчилгээний зардал	853,957,741.31	-853,957,741.31	-
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,512,342.91	-132,512,342.91	-
6	Үндсэн цалин	132,512,342.91	-132,512,342.91	-
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,830,071.40	-4,830,071.40	-
12	Тэтгэврийн даатгал	4,830,071.40	-4,830,071.40	-
22	Хангамж, бараа материалын зардал	38,324,736.00	-38,324,736.00	-
23	Бичиг хэрэг	13,807,166.00	-13,807,166.00	-
24	Тээвэр (шатахуун)	23,394,400.00	-23,394,400.00	-
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	823,170.00	-823,170.00	-
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	300,000.00	-300,000.00	-
39	Томилолт, зочны зардал	16,216,500.00	-16,216,500.00	-
41	Дотоод албан томилолт	16,216,500.00	-16,216,500.00	-
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	99,237,800.00	-99,237,800.00	-
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,237,800.00	-99,237,800.00	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал	562,836,291.00	-562,836,291.00	-
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	562,836,291.00	-562,836,291.00	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	853,957,741.31	-853,957,741.31	-
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	853,957,741.31	-853,957,741.31	-
121	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	597,512,554.31	-597,512,554.31	-
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	254,782,187.00	-254,782,187.00	-
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,663,000.00	-1,663,000.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(0.00)	0.00	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	110.00	-	100.00
134	Удирдах ажилтан	2.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	83.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	25.00	-	100.00

Хавсралт

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.19	Аудитын нэр: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код: САГ-2019/72/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Үндсэн хөрөнгийн элэгдэлийг илүү байгуулсан.	4,913.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	А.Болор-Эрдэнэ
2	Цалин, хөлс тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан татварийн тооцоолол зөрүүтэй байна.	5,894.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	А.Болор-Эрдэнэ
3	Кассын дансанд байгаа өмнөх оны үлдэгдэл болох 111,6 мянган төгрөгийг харилцах дансанд тушаагаагүй байна.	111.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	А.Болор-Эрдэнэ
	Дүн	10,919.3			

